

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ГАЗРЫН 2019 ОНЫ 05 ДУГААР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 05 дугаар сарын 25

Замын-Үүд сум

Тус газар нь Монгол улс, Олон улсын хэлэлцээр, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Боомтын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145, 339, 146 дугаар тогтоол, журам тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актууд, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаал, албан даалгаврыг тус тус удирдлага болгон гадаадын иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилэхэд анхаарч 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1 Монгол Улсын виз, зөвшөөрөл, хяналт шалгалтын талаар:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолыг тус тус үндэслэн виз хүссэн 3 орны 67 иргэнд зохих ангиллын визийг олгож, визийн хураамж болох 2,284,000.00 төгрөгийг Төрийн сангийн дансанд нь төвлөрүүлэн ажилласан. Үүнд:

- Нэг удаагийн орох – 2 иргэн
- Нэг удаагийн гарах-орох – 22 иргэн
- Визийн шилжүүлэг – 39 иргэн
- Дамжин өнгөрөх -4 иргэн

1.2 Хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын иргэдийн талаар:

Хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын 1471 иргэн /давхардсан тоогоор/-ний хөдөлгөөнд бүртгэлээр хяналт тавьж ажилласан.

1.3. Алдаатай визийн талаар:

Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаас алдаатай олгогдсон БНХАУ-ын 39 иргэний визийг илрүүлэн, холбогдох арга хэмжээг авч визийн засвар хийж хилээр нэвтрүүлсэн.

1.4 Түр ирэгч бүртгэлийн талаар:

БНХАУ-ын 70, Португаль улсын 2 иргэнийг түр ирэгчээр бүртгэн, бүртгэлийн хураамж болох 144,000 төгрөгийг зохих дансанд төвлөрүүлсэн.

1.5. Хасалт хийсэн талаар:

Түр ирэгчийн хасалт хийлгэхийг хүссэн БНХАУ-ын 70 иргэн, Португаль улсын 2 Зөрчлийн тухай хууль зөрчсөн БНХАУ-ын 8, байгууллагын даргын шийдвэрээр Монгол Улсаас албадан гаргасан БНХАУ-ын 1 иргэнд хасалт хийсэн байна.

1.6. Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар:

БНХАУ-ын 113 иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч, мэдээллийг Төвд хүргүүлж ажилласан.

1.7. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22.1.6-д заасны дагуу Монгол Улсад байх болон буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй БНХАУ-ын 62 иргэнийг улсын хилээр нэвтрүүлэлгүй буцаан ажилласан.

1.8. Захиргааны арга хэмжээ авсан талаар:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн БНХАУ-ын 8 иргэнд 880,000.00 төгрөг, уригч 3 байгууллагын 4 иргэнд 320,000.00 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Монгол Улсад хууль бусаар хөдөлмөр эрхэлсэн БНХАУ-ын 3 иргэнийг ГИЭЗБТх-ийн 37.1.7, Зөрчлийн тухай хуулийн 16.2-1.4-д зааснаар торгуулийн арга хэмжээ авч албадан гаргасан.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн ДГ-2019/05 дугаар удирдамжийн дагуу Хяналтын Улсын ахлах байцаагч Б.Баярхүү, хяналтын улсын байцаагч Б.Сүлд-Очир, мэргэжилтэн П.Гантулга, Г.Төрболд нарын бүрэлдэхүүнтэйгээр 05 дугаар сарын 14, 15, 16-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг сум, Говьсүмбэр аймгийн Баян тал, Сүмбэр, Шивээговь сумын нутаг дэвсэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрт ажиллаж байгаа гадаадын иргэдийн бичиг баримтанд төлөвлөгөөт хяналт, шалгалтыг явуулж нийт 17 аж ахуйн нэгж байгууллагын 102 иргэн хамрагдсан. Шалгалтаар зөрчил, дутагдал илрээгүй аж ахуйн нэгж байгууллагуудаас объектын судалгаанд шаардлагатай материалуудыг авч баяжилт хийн, хууль журмын дагуу ажиллах талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн талаар:

Тайлант хугацаанд газрын дарга 4 тушаал гаргасан ба үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээ, тус газрын үйл ажиллагааны тайланг гаргаж холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

2.2. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар

Тайлант хугацаанд бусад байгууллагаас ирүүлсэн 13 албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэлжүүлэн, хариутай 3 албан бичгийг хугацаанд өгч, 7 албан бичиг боловсруулжээ.

Албан хаагчдаас чөлөө хүссэн 5 өргөдөл ажилд орох хүсэлт гаргасан /хүүхэд асрах чөлөөтэй байсан/ 1 өргөдлийг тус тус хүлээн авч, ажилд орох өргөдлийг төвд хүргүүлэн шийдвэрлүүлж бусад өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаа.

Тус газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн гомдол байхгүй болно.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар

Замын-Үүд сумын цагдаагийн хэлтэстэй хамтран 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдөр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал цаашдын хандлага” сэдвээр сургалт зохион байгуулж сургалтанд нийт 15 албан хаагч хамрагдсан.

2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

2019 оны 04 дүгээр сарын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган ndaatgal.mn цахим сайтад шивж, 27 албан хаагчийн нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийж, нийгмийн даатгалын тасгаар баталгаажуулсан.

“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган ажилласан талаар:

✓ Тухай бүрт нь оруулах мэдээлэл-8

✓ Сар бүр оруулах мэдээлэл-3 нийт 11 мэдээллийг хуулийн хугацаанд

шилэн дансны сайтад шивж байршуулсан.

Үнэт цаасны 04 дүгээр сарын тайланг хяналтын улсын байцаагч нараас хүлээн авч хянан, 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Санхүү, хангалт үйлчилгээний газарт хүргүүлсэн.

2019 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Төв газар болон Дорноговь аймаг дахь газраас Замын-Үүд сумын Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн орлого:

/төгрөгөөр/

Замын-Үүд сумын Төрийн сангийн данс	Гадаадын иргэн харьяатын газар	Дорноговь аймаг дахь газар	Нийт дүн
Хүү торгуулийн орлого	20,000.00	1,180,000.00	1,200,000.00
Улсын тэмдэгтийн хураамжийн орлого	98,555,400.00	8,876,000.00	107,531,400.00

Төв газрын дансанд 04 дүгээр сарын 30-ний өдрийн байдлаар визийн хуудасны үнэ 735,800.00 төгрөгийг шилжүүлсэн байна.

2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 41,414,300.00 төгрөгийн санхүүжилт авч, зарлага 33,492,890.78 төгрөгийг Замын-Үүд төрийн сангаар хянуулан гүйлгээг хийсэн. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил- 24,967,481.88 төгрөг

- Нийгмийн даатгалын шимтгэл- 2,382,842.18 төгрөг
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал- 323,974.00 төгрөг
- Тээвэр шатахууны зардал- 1,580,000.00 төгрөг
- Хангамж, бараа материалын зардал-1,081,692.72 төгрөг
- Урсгал засварын зардал-162,900.00 төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал- 2,000,000.00
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал-994,000.00

2019 оны 04 дүгээр сарын няравын тайланг хүлээн авч орлого зарлагын гүйлгээг хянан баталгаажуулсан.

Засвар үйлчилгээний талаар:

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 28,747,925.00 төгрөгийн санхүүжилтээр “Дорноговь аймаг дахь газрын албан конторын дээвэр засвар”-ын ажлыг Улаанбаатар хотын “Хос шугам” ХХК ажил гүйцэтгэхээр шалгарч, сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Батдуламтай ХО-А/21/2018 дугаартай ажлын гэрээг байгуулсан. Уг гүйцэтгэгч байгууллага нь 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зураг төсвийн дагуу дээвэрт цементэн тэгшилгээ, мембран, хайрган дээвэр зэрэг хучилтын ажил, барилгын гадна талын төмөр эдлэлүүд ус зайлуулах хоолойг шинээр хийж гүйцэтгэн, 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдөр ажлыг бүрэн хийж дуусгасан. Сумын ЗДТГ-аас гүйцэтгэгч байгууллагаас гүйцэтгэлийн тайлан мэдээг хүлээн авч, ажил хүлээлцэх комиссыг зохион байгуулж, 2019 оны 05 дугаар сарын 31-ны дотор ажлыг хүлээлгэн өгөхөөр болсон. ГИХГ-ын санхүү, хангалт үйлчилгээний газрын ахлах мэргэжилтэн Г.Мөнхзаяа, Дорноговь аймаг дахь газрын сантехникч М.Лутбаяр нар гүйцэтгэлийн хяналтыг хийж ажилласан.




Дараа



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын түрээсийн гэрээгээр тус газрын албан өрөөг Замын-Үүд сум дахь Төрийн банк түрээслэн ажилладаг бөгөөд үйлчлүүлэгч нарт нээлттэй, шуурхай үйлчилгээг үзүүлэх үүднээс албаны байрны зүүн талд хаалга гаргаж, шат довжоо болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх шатыг өөрсдийн хөрөнгөөр хийж ГИХГ-ын санхүү, хангалт үйлчилгээний газрын ахлах мэргэжилтэн Г.Мөнхзаяа, мужаан Т.Даваапунцаг, Дорноговь аймаг дахь газрын сантехникч М.Лутбаяр нар ажлыг хийж гүйцэтгэлээ.



Албан хаагчдын амьдрах ая тухтай нөхцөл байдлыг хангах үүднээс 3 өрөөний дотор хаалгыг шинэчлэн сольж суулгасан.



2.4. Мэдээллийн технологийн чиглэлээр

Тайлант хугацаанд газрын хэмжээнд мэдээлэл технологийн ажлын хэвийн үйл ажиллагааг хангаж, эрхэлсэн ажлын хүрээнд удирдлагыг мэдээллээр ханган, нийт 12 удаагийн дуудлага хүлээн авч албан хаагчдын компьютер, техник хэрэгсэлд шаардлагатай үйлчилгээг хийсэн. Байгууллагын дотоод сүлжээ “e-office” програм ажиллахгүй байх хугацаанд Говьсүмбэр, Сайншанд дахь төлөөллүүдэд нэмэлт компьютер бэлдэж интернет сүлжээ хүлээн авагчтай хамт явуулсан болно.

Гурав. Бусад

БНСУ-д 2019 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 05-р сарын 05-ны өдрийн хооронд “Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын чадавхи бэхжүүлэх” сургалтанд Сүлжээний инженер Д.Хоролсүрэн нь хамрагдсан.

Монгол Улсын Шадар сайд аймгийн Засаг даргатай байгуулсан төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний дагуу 2019 оны 05 сарын 09,10-нд Замын-Үүд суманд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд газрын дарга болон нийт албан хаагчид зохион байгуулагдаж газрын дарга болон нийт албан хаагчид хамрагдлаа.

Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Сургалтанд оролцуулах тухай” 34 дүгээр тушаалын дагуу Замын-Үүд-Эрээн хотын эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлын хүрээнд ӨМӨЗО-ны Эрээн хотын Засгийн ордон, Худалдааг дэмжих хорооноос Хан Жэу хотын Жэ Жяны их сургуультай хамтран зохион байгуулсан сургалтанд Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын дарга П.Тулга 2019 оны 05 дугаар сарын 12-18-ны өдрүүдэд амжилттай оролцсон.

Газрын даргын 2019 оны 01-03/09, 01-09/11 дугаар удирдамжийн дагуу Хяналт шинжилгээ дотоод аудит, орон нутгийн хэлтсийн дарга Л.Батсүх, ахлах мэргэжилтэн хяналтын улсын байцаагч Ц.Пүрэвсүрэн, хяналтын улсын байцаагч Б.Ариунбилэг, жолооч

М.Батболд, захиргаа, удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Ж.Алтангэрэл, архивын эрхлэгч /гэрээт ажилтан Л.Дэлгэрцэцэг нар 2019 оны 05 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд Дорноговь аймаг дахь газрын албан хаагчдад болон Хилийн цэргийн 0108-р ангийн шалган нэвтрүүлэх албаны шалгагч бүрэлдэхүүнд Монгол Улсын виз олгох, Монгол Улсад оршин суух болон бүртгэх журмын талаар сургалт зохион байгуулж, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөх заавар болон бусад эрх зүйн актыг үндэслэн төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүллээ.

Хилийн боомтын үндэсний зөвлөлийн дарга Ч.Хүрэлбаатараас 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 1 дүгээр зөвлөмжийн хоёрдугаар хэсэгт заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газар нь Замын-Үүд авто замын боомтыг шинэ төлөвлөлтөөр буулгах, шилжүүлэх хөрөнгийн асуудлаар байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хэлэлцэж бүтээн байгуулалтын газар чөлөөлөх асуудлыг шийдвэрлэж ажиллаа.

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдээ, мэдээлэл өгөх зорилгоор Монголын хуульчдын холбоо, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс хамтран “Хуульчийн про боно өдөр-2019” өдөрлөгийг 05 сарын 01-ны өдөр дуу бүжгийн “Боржигон чуулга”-н гадна талбайд зохион байгуулагдаж, өөрийн байгууллагын үйл ажиллагаа болоод иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгч 5 төрлийн 48 ширхэг гарын авлага тараах материал тарааж ажилласан.

Говь-Сүмбэр аймгийн Засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам” 04 сарын 27-ны өдрөөс 05 сарын 05-ны өдрүүдэд 8 төрлөөр, 92 аж ахуйн нэгж, байгууллага 21 багт хуваагдан тус газрын мэргэжилтэн Г.Төрболд аймгийн ИТХурал, аймгийн ЗДТГазар, Аудитын газар, Орон нутгийн өмчийн газар, Хүний эрхийн комиссын төлөөлөл, Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн төлөөлөлтэй нэг баг болж 4 төрөлд оролцлоо.

Үндэсний хэл бичгийн өдрийн хүрээнд “Монгол бичгийн нийгэмлэг” НҮТББ-ын Замын-Үүд дэхь салбар болон Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЗДТГ-аас 2019 оны 05 дугаар сарын 23-24-ны өдрүүдэд зохион байгуулагдсан монгол бичгийн уралдаанд байгууллагаа төлөөлөн мэргэжилтэн А.Анужин хичээнгүй бичиг төрөлд оролцсон.

Төв газраас 3 ширхэг компьютер, 3 ширхэг принтер, 6 ширхэг энгэрийн камер, хүлээн авч энгэрийн камерыг жагсаалтаар хяналтын улсын байцаагч нарт хүлээлгэн өгсөн.